



2025 он 04 сар 17 өдөр

Дугаар 18

Улаанбаатар хот

Зээлийн эрх нээх гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах тухай

“Говь” ХК нь “Таван Богд Холдингс” ХХК болон түүний охин компаниудтай хамтран “ХААН” банктai байгуулсан зээлийн эрх нээх гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах асуудлыг хэлэлцсэний үндсэн дээр, Монгол Улсын Компанийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 75.1, 76 дугаар зүйлийн 76.1.17, 76.1.18, 89 дүгээр зүйлийн 89.1, 92 дугаар зүйлийн 92.1 дэх заалтыг тус тус удирдлага болгон “Говь” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс **ТОГТООХ нь:**

1. “Говь” ХК болон “Таван Богд Холдингс” ХХК түүний охин компаниудын хамт “ХААН” банктai байгуулсан 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн ЗЭНГ24/39 тоот Зээлийн эрх нээх гэрээнд дараах нэмэлт, өөрчлөлт оруулахыг зөвшөөрсүгэй. Үүнд:
 - 1.1. “Улаанбаатар Гурил” ХХК-ийн “Хаан Банк”-тай байгуулж буй “Хөдөө аж ахуйн тогтвортой үйлдвэрлэлийг дэмжих эргэлтийн хөрөнгийн зээл”-ийн хүрээнд Эрхийн хэмжээг 15,000,000,000 /арван таван тэрбум/ төгрөг хүртэл буюу түүнтэй тэнцэх хэмжээний гадаад валютаар ашиглуулах,
 - 1.2. Эрх ашиглалтын хугацаа: Дээрх “Гурил, тэжээл, түүхий эд авахад зориулан олгох эргэлтийн хөрөнгийн зээл” төлөгдөж дуусах хүртэл,
 - 1.3. “Таван Богд Холдингс” ХХК нь 40.0%, “Таван Богд” ХХК-ийн 50.0% хувьцаа эзэмшдэг охин компани “Таванбогд Констракшн Машинери” ХХК-ийг ЗЭНГ24/39 тоот Зээлийн эрх нээх гэрээнд хамтран зээлдэгчээр нэмэхийг зөвшөөрсүгэй.
2. Дээрх хэлцэл нь сонирхлын зөрчилтэй хэлцэлд тооцогдох тул Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хараат бус гишүүдийн дийлэнх олонхын саналаар шийдвэрлэн баталсугай.
3. Зээлийн эрх нээх нэмэлт гэрээ, барьцааны нэмэлт гэрээ, холбогдох бусад гэрээ, бичиг баримтад Говь ХК-ийг төлөөлж гарын үсэг зурах эрхийг “Таван Богд Холдингс” ХХК-ийн Санхүү удирдлага хариуцсан захирлын үүрэг гүйцэтгэгч /Б.Оргил/-д олгосугай.

ТУЗ-ИЙН ХАРААТ БУС ГИШҮҮД



Д.ГЭРЭЛМАА

А.ЖАРГАЛМАА

Д.ХҮРЭЛБААТАР

Б.ЦЭЭНЯМ